

ИХ МОНГОЛ УЛСАД “СОЁРХОЛ”, “ТҮШЭЭ” ГАЗАР НУТАГ ГЭЖ БАЙСАН УУ ?

Ж.ГЭРЭЛБАДРАХ

МУБИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч
gerelbadrakh@msue.edu.mn

Түлхүүр үг: Их Монгол Улс, хааны газар, дархалсан газар, мянганы газар, соёрхол газар, түшээ газар

Их Монгол улсын бэлчээр нутгийн эзэмшил, өмчлөлийн хэлбэрүүдийн талаар олон судлаач багагүй судалж, зүйл бүрээр бичсээр иржээ. Энэ талаарх судалгаа зохих түвшинд сайн хийгдсэн хэдий ч эргэж нягтлах, засч залруулах зүйл бас бий.

Их Монгол улсад ирсэн Хятадын өмнөд Сүн улсын элч Сюй тин тэмдэглэлдээ “миний өнгөрсөн элс манхын газарт Татарын эзэн ба хунтайж, тайж, гүнж, угсаа төрлүүд бүр өөр өөрийн газар нутагтай, тус тусын харьяа ардаас бүр үхэр, морь, тэрэг, улаа албадан хонийн мах, гүүний цэгээгийн алба татна. Лав татар хүн бэлчээрийн газрыг хэсэглэн хуваалцан захирч, хүн бүрээр алба гаргалгамуй. Эрхэм доод гэх ялгалгүй нэгээхэн хүн ч хэлтрэн гарч чадахгүй юм. Бас тус бүрээс алба тархааж олон газрын зам өртөө албан зардалд хэрэглэх нэгэн зүйлийн татварыг дээд доод хүн ялгалгүйгээр явуулна. Эдгээр нь Монгол газрын алба буюу”¹ хэмээжээ. Уг мэдээнээс сэдэвт холбоотой хоёр зүйлийг мэдэж авна. Эхнийх нь, язгууртан бүр өөрийн гэсэн бэлчээр нутагтай байжээ. Удаах нь, монголчууд бэлчээр нутгаа хуваан захирдаг, бүр тодруулбал хуваан эзэмшдэг байсан гэж ойлгоно.

Их Монгол улсад хааны нутаг, дархалсан нутаг, алтан урагтаа өгсөн өмч хувь нутаг гэсэн газар өмчлөлийн гурван хэлбэр, мянганы нутаг гэх газар эзэмшлийн хэлбэр байсан нь судалгаагаар нэгэнтээ тогтсон билээ. Эл өгүүлэлд тэр үеийн мянганы нутаг, дархалсан нутгаас тусдаа “соёрхол нутаг”, “түшээ нутаг” гэсэн газар эзэмшлийн хэлбэрүүд байсан, эсэхийг нягтлан авч үзсү.

1. “Соёрхол нутаг” гэгч байв уу ?

Монгол улсын албан түүхэнд Их Монгол улсад соёрхол газар байсан хэмээн үзсээр иржээ. 1966 оны “БНМАУлсын түүх”-энд соёрхол газрыг салаа утгатай авч үзсэн байдаг. Эхлээд Их Монгол улсын үед “газар эзэмшил нь гурван зүйл байсан

¹ Пэн да я, Сюй тин. “Хар татарын тухай хэргийн товч”-ийн тайлбарлан гэрчилсэн бичиг. Мөнхзаяа орчуулав. Хайлаар. 1985. т.192

нь: а. Улсын газар буюу мянгатын нутаг, б. Дархалсан нутаг. в. Соёрхлын газар болно” хэмээжээ. Дараа нь “Соёрхлын газар бол Монголын хаанаас эхний үед төрөл төрөгсөддөө эзлэн захирсан суурьшмал аж ахуйт орноос энэ тэр муж, хот тариалангийн газрыг татвар авч байхаар үүрд өмч болгон олгосон газар бөгөөд жишээлбэл: Шихихутагт олгосон “байшин гэртэй, балгас хоттой” иргэд бол даруй бидний өгүүлэн буй соёрхол газрын нэг хэлбэр юм”² гэж бичжээ. Үүнээс үзэхүл, соёрхол газар гэдэг нь Чингис хаанаас төрөл төрөгсөддөө өмч болгон өгсөн газар ажээ. Соёрхол газрыг эзэмшил ба өмч гэж хоёр өөрөөр үзсний учир шалтгааныг хэлэхэд бэрх байна.

2003 онд зохиосон “Монгол улсын түүх”-ийн ботид дээрхийг яг тэр чигээр нь үг үсэггүй хуулан бичсэн ажээ.³ Мөн тэнд Их Монгол улсад газар эзэмшлийн гурван хэлбэр байсны нэг нь “дархалсан нутаг” гэсэн атлаа “Дархлан олгосон нутаг гэдэгт бид Чингисээс Сорхон шар, Хорчи, Илжигидэй зэрэг ноёдод олгосон соёрхол газрыг оруулж байна”⁴ хэмээн хоорондоо уялдаагүй, утгын хувьд зөрчилтэй бичжээ. Чингэвэл дархалсан нутаг, соёрхол газар хоёр нь нэг зүйл болохоор байна.

Тэр байтугай Цагадайн улсын (1222-1370) дараа тогтсон Төмөрийн улсад (1370-1507) ч соёрхол гэдэг газар эзэмшлийн хэлбэр байсан хэмээжээ. “Төмөрийн үед газар эзэмшлийн гол хэлбэр нь үе залгамжлан эзэмших соёрхол болж байв. Соёрхол хүртсэн хүн ханы төлөө цэрэг авч дайнд явах үүрэгтэй байлаа. Соёрхлын газар эзэмшигч этгээд өөрийн газар нутгийн дотор алба татвар, зарга заальхай, засаг захиргааны бүр эрхийг толгой мэдэн шийдэх эрхтэй байжээ. Соёрхлын газарт төв засгийн газрын ямар ч албаны хүн зоргоор орох эрхгүй байжээ”⁵ гэж бичсэн ажээ.

Судлаачдын үзэл баримтлал. Их Монгол улсын бүрэлдэхүүн улсын нэг болох Ил хаадын улс, Цагадайн улсын дараах Төмөрийн улсад “сойэргл” (соёрхол) гэдэг газар нутаг бэлэглэх ёс журам байсан тухай Зөвлөлтийн судлаач Б.Н.Заходер, А.М.Беленицкий, А.Ю.Якубовский нар олонтоо бичсэн байдаг. Тэдний нэг И.П.Петрушевский авгай, соёрхлыг икта газрын цаашдын хөгжил байсан агаад “был административно-судебный иммунитет”⁶ (засаг захиргаа- хууль цаазны дархан халдашгүй дархан эрхтэй байсан) гэж үзсэн юм. Мөн тэд соёрхлыг их хэмжээний, 1-2 тосгоныг хамарсан бага хэмжээний гэсэн янз бүр байсан, газар тариалангийн болон нүүдлийн тал нутгийг аль аль нь соёрхол байсан, соёрхол үе улирах эрхтэй байв гэх зэргээр бичсэн байдаг. Тэд тухайн цагийн сурвалжид хаанаас гавьяа байгуулсан доод хүмүүст нутаг дэвсгэрийг соёрхол болгон өгсөн тухай өгүүлснийг тийм нэртэй тусгай газар нутаг, тусдаа ёс журам байсан гэж андуу ойлгож тайлбарласан нь илт байна.

Тэдний дараахан Японы эрдэмтэн М.Мүраками тусгайлсан судалгаа хийж, “Тоёо Гакухо” (Дорно дахины нийгэмлэгийн тайлан) сэтгүүлийн 1961 оны 44-р ботийн 3 дугаарт “Монгол улсын газар эзэмшил “соёрхол”-ын гарал үүслийн тухайд” (т.305-339) гэсэн өгүүлэл хэвлүүлжээ.⁷ Тэрбээр “The Mongol term *soyurqal*, which meant a kind of fiefdom in Činggis Qan’s Empire of the early thirteenth century, was obviously derived from the verb *soyurqa-qu*, ‘to grant a favor’” (Монголын соёрхол гэдэг хэллэг

² БНМАУ-ын түүх. тэргүүн боть. УБ., 1966. т. 218

³ Монгол улсын түүх. дэд боть. УБ., 2003. т. 100

⁴ Монгол улсын түүх. дэд боть. УБ., 2003. т. 99

⁵ Монгол улсын түүх. дэд боть. УБ., 2003. т. 284

⁶ И.П.Петрушевский. *Земледелие и аграрные отношения в Иране XIII-XIV веков*. М-Л. 1960. с. 273

⁷ М. Murakami. On the origin of the Fiefdom ‘soyurqal’ under the Mongol dynasty. *The Toyo Gakuho (report of the Oriental Society)*. Vol. 44. № 3. December. 1961. pp. 1-35

нь 13-р зууны эхэн үеийн Чингис хааны эзэнт гүрний газар эзэмшлийн нэг төрөл байсан агаад ‘хайр хишиг хүртээх’ гэсэн утгатай соёрхох гэсэн үйл үгээс үүсэлтэй нь маргаангүй юм) гэж үзсэн байна. Улмаар “As *soyurqal* was a special favor of the Qan, the recipient was excused from the duties such as taxes and corvées otherwise to be assessed upon it by the State” (Соёрхол бол хааны тусгай хайр хишиг байв, түүнийг хүртэгч нь татвар гувчуур болон хүнд хүчир ажил зэрэг албан үүргээс чөлөөлөгдсөн өөрөөр хэлбэл төрд үнэлэгдэгсэд юм) хэмээжээ.

Ш.Нацагдорж, Д.Гонгор, Ч.Далай нарын эрдэмтэд М.Мүракамын Их Монгол улсад соёрхол гэдэг язгууртны газар эзэмшлийн хэлбэр байсан гэсэн судалгааг дагасан юм. Ш.Нацагдорж авгай (1972) эхлээд “соёрхол нь нэг талаар шагналын эзэмшил газар, нөгөө талаар засаг захиргааны ба шүүх таслах эрх дарх иммунитет ажээ”⁸ хэмээн үзэж байв. Дараа нь (1978) “Ер нь соёрхол XIII-XVI зууны үед Монголын хаадын өөрсдөө хүчин зүтгэсэн хүмүүст ямар нэгэн шагнал хишиг хүртээхийг хэлдэг байжээ”⁹ гэж зөвөөр бичиж байв. Бүр сүүлд (1991) тэрбээр “соёрхлын газар бол Монголын хаанаас эхний үед төрөл төрөгсдөдөө эзлэн захирсан суурьшмал аж ахуйт орны энэ тэр муж, хот тариалангийн газраас алба татвар авч байхаар үүрд өмч болгон олгосон газар бөгөөд жишээлбэл: Шигихутугт олгосон ‘байшин гэртэй, балгас хоттой’ иргэд бол даруй бидний өгүүлэн буй соёрхол газрын нэг хэлбэр нь юм”¹⁰ гэж 1966 оны БНМАУ-ын түүхийн ботийн бичвэрийг яг тэр хэвээр баримтлах болсон юм.

Д.Гонгор авгай, алтан ургийн бус талын язгууртанд олгосон соёрхол нутаг байсан гээд “уг үнэн байдлаар нь хэлэхүл эзэн хааны шадар нөхдийн “өмч нутаг” хэмээн нэрлэж болно”¹¹ гэж боджээ. Ч.Далай авгай, соёрхол нь газар эзэмшлийн нэг хэлбэр байсан бөгөөд улсын газар буюу мянгатын газраас “эзэмших газрын хувьд арай бага хэмжээтэй байсан”¹² гэж үзжээ. Чингэвэл соёрхол газар гэгч нь бага хэмжээний эзэмшил газар болох юм.

Соёрхол гэдэг үгийн утга. XV зууны үеийн “Мукаддимат Ал-адаб” хэмээх Монгол хэлний толь бичигт, *soyurqal*- милость (хайр, хишиг), *soyurqaqsan* – подаривший¹³ (бэлэглэсэн) гэж орчуулсан байна. О.Ковалевский авгай толь бичигтээ “*ᠰᠣᠶᠢᠷᠬᠣᠯ* пожалование, подарок; изъявление, благоволение, милость, благоволение. Action d'accorder, don, present; temoignage de bienveillance, grace, bienveillance”¹⁴ (хайрлан ачлах, бэлэг, илтгэн илэрхийлэх, таалал, өршөөл, соёрхол) гэж бичжээ.

Я.Цэвэл авгай бээр “СОЁРХОЛ зөвшөөрөл. *ᠰᠣᠶᠢᠷᠬᠣᠯ*; СОЁРХОХ 1. зөвшөөрөл өгөх; айлдан соёрхоно уу (хэлж өгнө үү); 2. хайрлах, өгөх; хэшиг соёрхох *ᠰᠣᠶᠢᠷᠬᠣᠯᠠᠭ*”¹⁵ гэж тайлбарласан байдаг. Үүнээс үзэхүл, соёрхох, соёрхол хэмээх нь 1), зөвшөөрөх, 2), хайрлах, 3), өгөх, шагнах гэсэн үндсэн гурван утгатай ажээ. Түүхэн сурвалж бичигт гарч буй соёрхол, соёрхох гэсэн үг дээрх гурван утгын аль алианаар хэрэглэсэн байдаг.

⁸ Ш.Нацагдорж. *Сум, хамжлага, шавь ард*. УБ., 1972. т. 17

⁹ Ш.Нацагдорж. *Монголын феодализмын үндсэн замнал (түүхэн найруулал)*. УБ., 1978. т. 57

¹⁰ Ш.Нацагдорж. *Чингис хааны цадиг*. УБ., 1991. т. 189

¹¹ Д.Гонгор. *Халх товчоон*. II. Халх монголчуудын нийгэм-эдийн засгийн байгуулал (XI-XVII зуун). УБ., 1978. т. 257

¹² Ч.Далай. *Их Монгол улс (1206-1260)*. Дэд дэвтэр. УБ., 1994. т. 61

¹³ Н.Н.Попше. *Монгольский словарь Мукаддимат Ал-Адаб*. Часть I-II. М-Л., 1938. с. 325

¹⁴ *Монгольско-Русско-Французский словарь*. Составленный профессором О.Ковалевскимъ. Томъ второй. Казань. 1846. с. 1407

¹⁵ Я.Цэвэл. *Монгол хэлний товч тайлбар толь*. УБ., 1966. т. 477

Монгол хэл арвин баялаг тул монголчууд ямарваа үгийг үндсэн гурван байдлаар ялгаатай хэлж, бичдэг. Тэр нь доромж хэллэг, энгийн хэллэг, хүндэтгэлийн хэллэг гурав юм. Тухайлбал, идэх гэдэг үгийг гудрах, цуслах (доромж), идэх (энгийн), зооглох (хүндэтгэл) гэж, унтаж амрахыг ногоорох, илжрэх (доромж), унтах (энгийн), нойрсох (хүндэтгэл) гэж тус тус гурван өөрөөр хэлж бичдэг. Үүнтэй адилаар зөвшөөрөх, хайрлах гэдэг үгсийн хүндэтгэлийн хэлбэр “соёрхох”, бас өгөх, хүртээх гэдгийн хүндэтгэлийн хэллэг нь “соёрхол” юм. Учир иймийн тул соёрхол, соёрхох гэдгийг өгөх хүртээх, зөвшөөрөх, хайрлах гэсэн утгаар ойлгох хэрэгтэй.

Сурвалжийн мэдээ. Эхлээд “Монголын нууц товчоон”-д Чингис хаанаас гавьяа байгуулсан, зөв хэрэг хийсэн хүмүүсийг зөвшөөрсөн, бас хайрласныг соёрхох гэдэг хүндэтгэлийн үгээр хэлсэн хэдэн мэдээг дурдая.

1.Баарины Наяа эцэг, ах нарын хамт Тайчуудын Таргудай Хирилтугийг барьж Чингис хаан руу хүргэж явахдаа эзнээ барьж өгөхгүй тавьж тавиулаад өөрсдөө дагаар очиход “*ta tus qan-ıyan tebčin yadaqsan setkil tanu jöb bui ke'en naya'a-yı soıurqaba*”¹⁶ (Та тус ханаа тэвчин ядсан сэтгэл тан зөв буй хэмээн Наяа-г соёрхов) хэмээн түүнийг хайрласан байдаг.

Наяа ноён Увас Мэргидийн захирагч Дайр усуныг охин Хуланы хамт осол эндэлгүй өөрийн биеэр хүргэж авчирсанд “*činggis-qahan qulan-qadun-ni soıurqaju ta'alaba naya'a-yin üges adali boldaju jöbsiyejü ünen ügetü aju'u ke'en yeke üyile tüsisü ke'en soıurqaba*”¹⁷ (Чингис хаан Хулан хатныг соёрхож таалав. Наяа-гийн үгс адил болдож зөвшөөж, үнэн үгт ажгуу хэмээн их үйл түшсү хэмээн соёрхов) гэж бичсэн байдаг.

Гүр хаан Жамуха сэцэн баригдаж ирээд Тэмүжинд “*anda soıurqa'asu namayı ötör nökc'e'esü anda jürüge-ben amumui je či anda soıurqaju ala'ularun čisu ülü qarqan ala'ul*”¹⁸ (анд соёрхвоос намайг үтэр нөгчөөвөөс анд зүрхээ амуумуй зэ чи. Анд соёрхож алуулруун цус үл гарган алуул) хэмээн хэлүүлж байв.

Тэмүжинийг хаан болно хэмээн ард олны өмнө сурталчилж өгсөн Хорчин зайранд хожим “*edö'e jöb tula soıurqaju ede oroqsat irgen-ü sayin eme-yı sayin öki üjeju qučın emes songquju a[b] ke'en jarliq bolba*”¹⁹ (Эдүгээ зөв тул соёрхож эд орогсод иргэний сайн эмийг, сайн охин үзэж гучин эмс сонгож ав хэмээн зарлиг болов)

Чингис хаанд Далан Балжудын байлдаанд амь үрэгдсэн Нэгүдэй Цагаан гуа-гийн хөвүүн Тоорил “*soıurqa'asu negüs aqa de'ü minu qari tutum bura tara bui soıurqa'asu negüs aqa de'ü-yü'en čı'ulqasuqai*”²⁰ (соёрхвоос Нэгүс ах дүү минь харь тутам бур тар буй. Соёрхвоос Нэгүс ах дүү юүгээн чуулгасугай) гэсэн хүсэлт тавьж зөвшөөрүүлж байв.

¹⁶ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 69

¹⁷ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 108

¹⁸ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 113

¹⁹ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 118

²⁰ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 125

1207 онд Монгол улсын баруунтай орших Харлугуудын Арслан хан дагаар орохоор ирэхэд “ese bulqaba ke'en činggis-qahan arslan-i soyourqaju öki ögüye ke'en jarliq bolba”²¹ (эс булхав хэмээн Чингис хаан Арсланг соёрхож охин өгье хэмээн зарлиг болов) хэмээжээ.

Мөн онд Алтайн нурууны цаана нутаглах уйгуруудын тэргүүлэгч Идүгүд бээр Монгол улсад дагаар орохоор Чингис хаанд хоёр элч явуулж “činggis-qahan soyourqa'asu altan büse-yin qorgi-dača al de'el-un hürtesün-eče olu'asu tabtu'ar kö'ün činu bolju gücü öksü ke'en öčijü ilējü'üi”²² (Чингис хаан соёрхвоос алтан бүсний горхиноос ал дээлийн үртэснээс олбоос тавдугаар хөвүүн чинь болж хүч өгсү хэмээн өчиж илгээжээ) хэмээн өгүүлдэг.

1207 онд Чингис хааны ахмад хөвүүн Зочи хойд зүгийн Ойн иргэдийг дайлаар оруулж ирэхэд Чингис хаан ихэд хайрлан магтсан тухай “činggis-qahan jöči-yi soyourqaju ügülerün kö'üd-ün minu aqa či ger-teče sayi qarču mör sayitu oduqsan qajar-a ere aqta-yi ülü sirqan ülü jöba'an öljeitü hoi-yin irgen-i oro'ulju ireba či irge čimada öksü ke'en jarliq bolba”²³ (Чингис хаан Зочийг соёрхож өгүүлрүүн, хөвүүдийн минь ах чи гэрээс сая гарч мөр сайт, одсон газраа эр, агтыг үл шарган үл зовоон өлзийт ойн иргэнийг оруулж ирэв чи. Иргэн чамд өгсү хэмээн зарлиг болов) хэмээн бичжээ.

Алтан улсын дайлж явахад Жүндү хотыг гаргаж өргөсөн эд зүйлийг хувьдаа авсан ноёдыг буруутгаж, тэдгээр зүйл одоо Чингис хааных болсон хэмээн огт аваагүй Шихи хутугийг магтсан талаар “činggis-qahan tende önggür arqai qoyar-i masi dongqotba sigi-qutuqu-yi yeke yosu setkijü'ü či ke'en masi soyourqaju üjegü-yin minu nidün songsqu-yin minu čikin bolju ülü-'ü aqu či ke'en jarliq bolba”²⁴ (Чингис хаан тэнд Өнгүр, Архай хоёрыг маш донгодов. Шихи хутугийг их ёс сэтгэжээ чи хэмээн маш соёрхож, үзэхийн минь нүдэн, сонсохын минь чихин болж үлүү аху чи хэмээн зарлиг болов) хэмээн өгүүлдэг.

Чингис хаан Сартуулын дайнд султан Мухаммедийг нэхүүлэхдээ “jebe sübe'etei qoyar-i masi soyourqaju jebe či jirqo'adai neretü büle'e tayiču'ud-ača irejü jebe bolba-je či”²⁵ (Зэв, Сүбээдэй хоёрыг маш соёрхож, Зэв чи Зургаадай нэрт бүлгээ Тайчуудаас ирж Зэв болов зэ чи) хэмээн хэлсэн байдаг.

Сартуулын Ургенч хотыг эзэлсэн дайны олзоо хөвүүд нь өгөөгүй тул хаан уурлан уулзаагүй талаар “qahan yekin eyin kilinglaju amu kö'üt buru'u-yan uqaju ayuba-je qoyiči-yu'an surtuqai kö'üt aburi-yan alqasa'ujai soyourqa'asu a'ulja'ulu'asu bolqu-yü”²⁶ (Хаан яахин ийн хилэгнэж аму. Хөвүүд буруугаа ухаж айв зэ. Хойч юугаан суртугай. Хөвүүд авираа алгасуузай. Соёрхвоос уулзуулбаас болох уу) хэмээн гуйсан ажээ.

²¹ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 135

²² Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 136

²³ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 137

²⁴ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 148

²⁵ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 154

²⁶ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 156

Дээр өгүүлж буй “соёрхоос” гэдэг үгийг зөвшөөрвөөс, “соёрхож” гэдэг үгийг хайрлах гэсэн утгаар түлхүү хэрэглэжээ.

2. Чингис хаанаас бусдад шан хишиг, бэлэг, эрх мэдэл өгснийг “соёрхол” гэсэн хүндэтгэлийн хэлбэрээр өгүүлсэн мэдээнээс хэдийг иш татвал,

1206 онд Монголжин улсыг байгуулж Тэмүжин дахин Чингис хаан цол аваад “ulus bayi’ululčan yabulduqsat-ta minqan minqalaju minqad-un noyat tüsiјü soyrqal üge ügülesü ke’en jarliq bolba”²⁷ (улс байгуулалцан явалдагсдад мянган мянгалж мянгадын ноёд түшиж соёрхол үг өгүүлсү хэмээн зарлиг болов) гээд 88 мянганы ноёдыг томилсон байдаг. Бас гавьяа байгуулсан хүмүүст эрх мэдэл, албан тушаал өгснийг “cinggis-qahan jarliq bolurun tusatan-a soyrqal öksü”²⁸ (Чингис хаан зарлиг болруун тустанаа соёрхол өгсү) хэмээн өгүүлжээ.

Их хааны өргөмөл дүү Шихи хутугу “sigi-qutuqu ügüлерin bo’orču muqali-tan ken-eče hüle’ü tusa kile’e ken-eče hüle’ü gücü ögüle’e soyrqal ökdegüya bi ya’un duta’u tusa ese bolulu’a ...edö’e nada yambar soyrqal ögümü”²⁹ (Шихи хутугу өгүүлрүүн Боорчу, Мухалитан хэнээс илүү тус хийлээ. Хэнээс илүү хүч өглөө. Соёрхол өгдөхүйеэ би юун дутуу тус эс боллоо. ...эдүгээ надад ямар соёрхол өгмү) гэх зэргээр нилээн хэл ам хийж албан тушаал, харьяат нутаг иргэн авч байжээ.

Нэгэн үе Тэмүжиний хойд эцэг болж явсан, Хэрэйдэд хууртаж баригдахаас сэргийлж амийг нь амарсан Мэнлигт “tere tusa-yi sayi setkiјü uruq-un uruq-a gürtelē ker umartaqdaqu tere tusa setkiјü edö’e sa’uri ene nu’u huја’ur-a sa’ülju hon-tur sara-tur sataјu öklige soyrqal čimadu öksü”³⁰ (Тэр тусыг сайн сэтгэж, ургийн ургаа хүртэл хэр умартагдах. Тэр тус сэтгэж эдүгээ суурь нугу язгуураа суулгаж, онд сард саатаж, өглөг соёрхол чамд өгсү) хэмээн зарлиг буулгаж байв.

Чингис хаан үнэнч баатар Уругудын Жүрчидэйд өөрийн хатан Ибаха бэхийг бэлэг болгон өгөхдөө “cinggis-qahan ibaqa-beki-yi жүрчedei-ye soyrqaju ögürün”³¹ (Чингис хаан Ибаха бэхийг Жүрчидэйе соёрхож өгрүүн) хэмээн сургаал захиасаа хэлсэн байдаг.

Чингис хаан эрт цагт нэг хүрээ болж Тэмүжинд даган ирж үнэнчээр зүтгэсэн Өнгүр буурчаас “edö’e yambar soyrqal abqu či ke’e’esü önggür ügüлерin soyrqal songqu’ulu’asu baya’ut aqa de’ü minu qari qari tutum-tur bura tara bui soyrqa[’a]su baya’ut aqa de’ü-yen či’ulqasuqai ke’e’esü je teyin baya’ut aqa de’ü-yen či’ulqaju či mede minqan ke’en jarliq bolba”³² (эдүгээ ямар соёрхол авах чи хэмээвээс Өнгүр өгүүлрүүн соёрхол сонгуулбаас Баягуд ах дүү минь харь харь тутамд бур тар буй. Соёрхоос Баягуд ах дүүгээ чуулгасугай хэмээвээс зэ тийн Баягуд ах дүүгээ чуулгаж чи мэд мянган хэмээн зарлиг болов) хэмээжээ.

²⁷ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 114

²⁸ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 115

²⁹ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 115

³⁰ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 116

³¹ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 119

³² Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 122

Чингис хаан нэгдсэн Монгол улсыг байгуулаад дан ганц хөвүүд, дүү нартаа төдийгүй “basa ökin uruq-iyau soyurqal ögüya ke’ebe”³³ (Бас охин урагаа соёрхол өгье хэмээв) гэсэн нь охиддоо харьяат иргэн, мал хуй өгсөн хэрэг юм.

1206 онд Онон мөрний хөвөөнөө Чингис хаан “tümed-ün minqad-un noyad-ta soyurqal üktekün metüs-e soyurqal ükçü soyurqal jarliq”³⁴ (...түмэдийн, мянгадын ноёдод соёрхол өгтөх мэтсээ соёрхол өгч, соёрхол зарлиг) буулгасан байдаг.

Тэмүжиний амийг аварч оргуулсан Тайчуудын Сорхон шарт нутаг дархлан олгосон тухай “edö’e bi tan-i soyurqa’asu yambar soyurqal ta’alaqun ta ke’eba sorqan-sira čila’un čimbai kö’üd-iyer-iyen bolun ügülerün soyurqa’asu nuntu[q] darqalasu merkid-ün qajar selengge-yi nuntuqlaju darqalasu basa busu soyurqal činggis-qahan medetügei ke’eba te’ün-tür činggis-qahan ügülerün merkid-ün qajar selengge-yi nuntuqlaju nuntuq ba darqalatqun-gü uruq-un uruq-a gürtel-e qorčila’ulju ötökle’ülju darqalatqun yesün aldal-tur ere’ü-tür bu orotaqai ke’en jarliq bolba”³⁵ (Эдүгээ би таныг соёрхвоос ямар соёрхол таалахун та хэмээв. Сорхон шар, Чулуун, Чимбай хөвүүдээрээ болон өгүүлрүүн соёрхвоос нутаг дархалсу. Мэргидийн газар Сэлэнгийг нутаглаж дархалсу. Бас бус соёрхол Чингис хаан мэдтүгэй хэмээв. Түүнд Чингис хаан өгүүлрүүн Мэргидийн газар Сэлэнгийг нутаглаж нутаг ба дархладхун. Ургийн ургаа хүртэл хорчлууулж өтөглүүлж дархладхун. Есөн алдалд эрүүд бүү ортугай хэмээн зарлиг болов) гэжээ.

1225 онд Чингис хаан Тангуд улсыг бүрэн эзлээд Боорчу, Мухали хоёрт их хүн ард, олз омог өгснийг “bo’orču muqali qoyar-a soyurqarun güčün-e medetele abtuqai ke’en jarliq bolba basa činggis-qahan jarliq bolurun bo’orču muqali qoyar-a soyurqal ögürün kitat irgen-eče ese ögüle’e ke’en”³⁶ (Боорчу Мухали хоёроо соёрхруун хүчнээ мэдтэл автугай хэмээн зарлиг болов. Бас Чингис хаан зарлиг болруун Боорчу, Мухали хоёроо соёрхол өгрүүн Хятад иргэнээс эс өглөө хэмээн) хэмээн өгүүлсэн байдаг.

Энэ бүх мэдээнээс Чингис хаан улс байгуулах хэрэгт үнэнчээр хүчин зүтгэсэн хүмүүст эрх мэдэл, албан тушаал, харьяат иргэн, бэлчээр нутаг өгч буй, шагнаж буй, бэлэглэж буй бүх мэдээг соёрхол гэдэг хүндэтгэлийн үгээр бичсэн нь тодорхой харагдана.

Хаанаас буюу төрөөс харьяат доод хүмүүст өгч буй бүх зүйлийг хүндэтгэн соёрхол хэмээдэг байв. Соёрхол гэдэг нь угтаа төрөөс буюу хаанаас доод хүмүүстээ өгч буй, шагнаж буй бүх төрлийн зүйлс юм. Харин доод хүмүүсээс хаанд өргөж буй эд зүйл, адуу мал, гувчуур зэргийг огт тэгж хэлэхгүй. Тухайн нэрээр нь хэлж байсан ажээ. Харин “Монголын нууц товчоон” дахь Өгэдэй хааны тухай өгүүлсэн хэсэгт “соёрхох, соёрхол” гэсэн үг гарахаа больдог. Энэ нь Өгэдэйн түүхийг бичсэн хэсэг сүүлд зохиогдсон болохын бас нэг гэрч юм.

³³ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 124

³⁴ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 127-128

³⁵ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 126

³⁶ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 160

Соёрхол гэдэг үгийг хэт махчилан үзвэл буруу ойлголтод хүрэх осолтой. Чингэвэл соёрхол иргэн, соёрхол эрх мэдэл, соёрхол түмэн, соёрхол мянган, соёрхол нутаг зэрэг илт зохиомол буруу ухагдахуунууд үүснэ. Тэдний нэг жишээ нь соёрхол нутаг ажээ.

Их Монгол улсад шинээр зохион байгуулсан мянганд өгсөн нутаг, онцгой гавьяа байгуулагчдад үе улиран захирах эрхтэй өгсөн дархалсан нутгийн аль аль нь Чингис хаанаас доод хүмүүстээ өгсөн буюу соёрхсон газар нутаг юм. Соёрхсон нутаг гэдэг ойлголтод төрөөс буюу хаанаас өмч болгож өгсөн, эзэмшүүлэхээр өгсөн бүх нутаг бэлчээрийг ойлговол зохилтой юм. Тэмүжин нэгэн үе хойд эцэг болж явсан Мэнлигт “*öklige soyuṅqal čimada öksü*”³⁷ (өглөг соёрхол чамд өгсү) гэж өглөг гэдэг үгтэй хамтруулан хэлсэн байдаг.

“Монголын нууц товчоон”-д соёрхол гэдэг үг 18 удаа гарна.³⁸ Соёрхох үндэстэй бусад үг болох соёрхвоос, соёрхов, соёрхож, соёрхон, соёрхруун, соёрхогдвоос, соёрхогдов, соёрхуулан гэсэн үг нийлээд 49 удаа гарч байна. Гэхдээ “соёрхол нутаг газар” гэж бичсэн үг, өгүүлбэр ор байдаггүй. “Судрын чуулган”-д соёрхол гэсэн үгийг перс хэл рүү орчуулалгүйгээр үндсэн хоёр (*soyüṅgāl*, *soyüṅgāmiši*) хэлбэрээр хэрэглэжээ.

Бэсүд аймгийн Зэв бээр Чингис хааны ам цагаан морийг харваж алснаа үнэнээр хүлээж түүнд хүчин зүтгэх болсон, мөн аймгийн Байдур хатан хоёр хөвүүнээ хаанд бараалхуулж түүний хайр хишгийг хүртээсэн, Харлугийн Арслан хаан Чингис хаанд дагаар орохоор ирэхдээ түүний таалалд багтах тухай өгүүлсэн хэсэгт *soyüṅgāmiši* хэмээн тэмдэглэсэн байдаг. Зөвлөлт улсын эрдэмтэд “Судрын чуулган”-ы орос хэвлэлд “*сийүргәймийши*” гэж бичээд “благоволение” (таалал, соёрхол), “пожалование”³⁹ (шагнал) гэж бичсэн байна. Харин В. Такстон авгай, уг үгийг тавьж тодотголгүйгээр *generous* (өгөөмөр сэтгэлтэй), *favor* (дэмжлэг, хамгаалал), *reward* (шагнал), *so kind* (их сайн санаатай) гэх зэргээр англи хэлнээ орчуулжээ.⁴⁰

Дөрффер авгай, эдгээр үгийг судлаад “*soyüṅgāl*” – “*erdliches steuerfreies Lehen*” (өвлөгддөг, татвараас чөлөөлөгдсөн шагнал), “*soyüṅgāmiši*” – “*Ghade erweisen*” (хайр, хишиг хүртээх) гэж тайлбарлажээ.⁴¹ Энэ бүхнээс үзэхэд, “Судрын чуулган”-д соёрхол гэсэн үгийг “Монголын нууц товчоон”-ы адилаар таалалдаа авсан, хайрласан, хишиг хүртээсэн гэсэн утгаар хэрэглэжээ.

Чингис хаан өөрийн бүрэн өмчинд байсан Их Монгол улсын нутаг дэвсгэрээ төрөл төрөгсдөө болон гавьяа байгуулагчдад өмчлүүлэх болон эзэмшүүлэхээр өгөх (соёрхох) бүрэн эрх эдэлж байв. Нилээнд хожим Мавераннахрын улсын Доголон Төмөр хаан тулалдааны өмнө цэргийнхээ сэтгэл санааг өргөх гэж бэлэг сэлт өгдөг байсныг “өглөг” хэмээн хүндэтгэн нэрлэдэг байсныг өглөгийн

³⁷ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 116

³⁸ *Word- and Suffix- Index to The Secret History of the Mongols based on the Romanized Transcription of L. Ligeti*. Compiled by Н. Kuribayashi and Choijinjab. Sendai. 2001. pp. 823-824

³⁹ Рашид ад-дин. *Сборник летописей*. том I, книга первая. перевод с персидского Л.А. Хегатурова. М.-Л., 1952. с. 194, 196; Рашид ад-дин. *Сборник летописей*. том I, книга вторая. перевод с персидского И.О. Смирновой. М.-Л., 1952. с. 152, 163

⁴⁰ Rashiduddin Fazlullah's Jami'u't-tawarikh: *Compendium of Chronicles. A history of the Mongols*. Part one. English translation and annotation by W.M. Thackston. Cambridge. 1998. pp. 110, 111, 205, 213

⁴¹ *Türkische und Mongolische elemente im Neupersischen*. Band I. Mongolische elemente in Neupersischen von Gerhard Doerfer. Wiesbaden. 1963. p. 351

тогтолцоо гэж үзэж болохгүйтэй адил харьяат хүмүүстээ нутаг өгөхдөө “соёрхол” гэж хэлснийг “соёрхол нутаг” гэдэг тусгай зүйл байсан хэмээн үзэх нь огт утгагүй зүйл юм.

Дүгнэлт. Угтаа “соёрхол газар” гэдэг газар өмчлөлийн ч, газар эзэмшлийн ч тусгайлсан хэлбэр байгаагүй ажээ. Монголчууд үгийг доромж, энгийн, хүндэтгэл гэсэн гурван янзаар хэлдэг агаад “соёрхол” нь өгсөн, бэлэглэсэн, шагнасан гэсэн үгийн хүндэтгэлийн хэлбэр юм. Чингис хаанаас гавьяа байгуулсан доод хүмүүстээ соёрхол хэмээн бэлчээр нутаг олгож байсныг хожмын түүхчид буруугаар ойлгоод соёрхлын тогтолцоо, соёрхол нутаг байсан гэх зүйлсийг хиймлээр зохион гаргаж иржээ.

2. “Түшээ нутаг” гэж байв уу ?

Түүх судлаач цөөнгүй эрдэмтэн Их Монгол улсын үед гэдэг тоу шиа, түшээ гэдэг үгийн талаар зохиол бүтээлдээ дурдсаар ирсэн ажээ. Тэд бол Янай (1938), Мин Шумин (1938), Котакэ ба Окамото (1954), Олбрихт (1954), Цай Мэйпияо (1955), П.Рачневский (1966), Ш.Ивамүра (1968), Ш.Нацагдорж (1978) нар юм.⁴² Түшээ-*ᠲᠦᠰᠡᠭᠡ* -tüsiy-e үгийн утгийн талаар О.Ковалевский авгай, “*ᠲᠦᠰᠡᠭᠡ* (tuchyé) опора, подпора: путы, кандалы, оковы. Сс66. Обязанности, должность. Appui, soutien, support: les chaines, les fers, obligations, devoirs de son état, ministère et district d'un mandarin”⁴³ (тулгуур, түшиг, тушаа, гав гинж, гинж, Сс66. Үүрэг, албан тушаал) хэмээн бичсэн байдаг.

Сурвалжийн мэдээ, судлаачдын тайлбар. Судлаачид “Юань улсын судар”-т гарах мэдээ баримтад голлон тулгуурлаж өөрсдийн санал дүгнэлтээ гаргажээ. Тэдний ашигласан олон мэдээнээс хамгийн гол гэж хэлж болох нь 120-р дэвтэрт буй Чингис хаанаас улс байгуулах хэрэгт ихэд тусалсан хэмээн Уругуд, Мангуд, Ихэрэс, Жалайр, Хонгирад таван аймгийн ноёдын үр удмынхныг тухайлан дурдсан бичвэр юм. Уг эхийг толилуулвал, “*朮赤台, 兀魯兀台氏。其先刺真八都, 以材武雄諸部。生子曰兀魯兀台, 曰忙兀, 與扎刺兒, 弘吉刺, 亦乞列思等五人。當開創之先, 協贊大業。厥後太祖即位, 命子孫各因其名為氏, 號五投下*” юм.

Дандаа (Дэмчигдорж) авгай тэрхүү зурвасхан мэдээг “Үлү үдэй хэмээмүй. Мангу хэмээмүй. Жалайр, Хонгира, Ихэлис зэргийн таван хүн тулгар байгуулах урьд их төрд тусалсан ажгуу. Хойно Тайцу сууринд суугаад зарлигаар хөвүүд ач нарыг өөр өөрийн нэрийг дагаж овог болготугай хэмээжээ. Цол таван харьяат хэмээмүй”⁴⁴ гэж орчуулжээ. Энд гарч буй “Үлү үдэй” гэж Уругудыг хэлж байна. Тэрбээр хятад эх дээр гарах *投下* тоу шиа гэдэг үгийг харьяат гэж орчуулсан ажээ.

А.Пунсаг авгай үүнийг “Зурачидай Уругууд овогтой. Дээдэс нь Начин баатар, авьяас билгэ баатар, хүчээр олон аймгийг оройлжээ. Хөвүүд нь Уругууд ай, Мангууд, Жалайр, Хугираад, Ихэрийс зэрэг таван хүн болой. Хожим нь Тайзу суурин залгамжлаад зарлигаар үр ач нарынх нь нэрээр овог болгож (*號五投下*) таван түшээ хэмээн нэрийдэв” гэж арай өөрөөр орчуулсан юм. Тэрбээр *投下* тоу шиа

⁴² Эдгээрээс П.Рачневский, И.Ивамүра, Ш.Нацагдорж нараас бусад зохиолыг олж чадаагүй тул дам ашиглав.

⁴³ *Монгольско-Русско-Французский словарь*. Составленный профессором О.Ковалевскимъ. Томъ третій. Казань. 1849. с. 1407

⁴⁴ *Юань улсын судар*. дэвтэр 120. Зөчидэй. Хятад хэлнээс орчуулсан Дэмчигдорж. Монгол улс. Үндэсний номын сан. т. 217-218

гэх ханзыг тухайн бичвэртэй уялдуулан түшээ аймаг, харьяат аймаг гэж утгачлан орчуулж болох юм гэж мөхөс надад тайлбарлаж өгсөн билээ.

Дээрх хоёр орчуулгаас харахад “Юань улсын судар”-т Уругуд, Мангуд, Жалайр, Хонгирад, Ихэрэс таван аймагт түшээ гэдэг газар нутаг олгосон тухай ямар нэг үг, өгүүлбэр байхгүй байна. Харин тэднийг харьяат эсэхүл түшээ гэж нэрийдсэн тухай л өгүүлжээ. Профессор Ц.Цэрэндоржийн тайлбарлаж хэлсэнээр, 投下 *tou xia* – *тоу шиа нь* доошоо шидэх, доошоо өгөх, олгох гэсэн утгатай ханз ажээ. “Юань улсын судар”-ыг зохиогчид хаад дээдсээс доод хүмүүстээ өгсөн нэр цолыг уг ханзыг ашиглаж бичсэн байна. Харин бидний түүхчид үүнийг “түшээ” гэдэг монгол үг байна хэмээн буруугаар ойлгож янз бүрээр ургуулан тайлбарлах болсон ажээ.

Судлаачдын үзэл баримтлал. Д.Гонгор авгай бээр түшээ цолтон байсан хэдий ч “тэдний аймаг-газар нутгийг түшээ гэж нэрлэсэнгүй”⁴⁵ хэмээн түшээ газар байгаагүй гэж үздэг. Харин Ш.Нацагдорж авгай “Онцгой гавьяат үйл бүтээсэн шадар хүмүүст эзэмшүүлэхээр өгсөн шагналын газар, энэ эзэмшил газар нь “түшээ” гэдэг нэртэй байсан бололтой”⁴⁶ гэж хэмээсэн байдаг. Тэрбээр ингэж үзэхдээ Монголын их хаадаас “идэх хот” хэмээн Хятадын хот суурин газраас алба гувчуур авах эрхийг ноёдод олгож байсныг түшээ газартай андууран ойлгосон байж ч магадгүй. Түүний ингэж үзэх болсон нь Германы эрдэмтэн П.Рачневский, Японы судлаач Ш.Ивамүра нарын судалгааны өгүүллийг андуу ташаа ойлгосноос үүдэлтэй бөгөөд “түшээ нутаг” гэдэг зүйлийг Монголын түүх судлалд бий болгожээ.

Анх П.Рачневский авгай “Zum Ausdruck “T’ouhsia” in der Mongolenzeit”⁴⁷ (Монголын үеийн “t’ouhsia” хэмээх үгийн тухайд) гэсэн өгүүлэл бичсэн билээ. Түүндээ “Юань улсын судар”-ын дээрх мэдээг герман хэлнээ орчуулахдаа Тэмүжин хаан ширээнд залраад улс байгуулах хэрэгт гавьяа байгуулсан таван аймгийн ноёдын үр ач нарт нэрийнхээ өмнө *тоу шиа* гэж нэрлүүлж байхыг зарлиг болгосон гэж ойлгосон байна. Тэрхүү мэдээг “Shuch’iht’ai (Jürçitai) war ein Angehöriger der Sippe der Wulu-wut’ai (Uru’utai). Sein Vorfahr Lachen-patu (Najin-ba’adur) zeichnete sich durch seine kriegerische Tüchtigkeit und seine Tapferkeit aus. Die Nachkommen des Stammes hiessen die einen Wuluwut’ai (Uruutai), die anderen Mangwu (Mang’ut). Zusammen mit den Chalaerh (Jalair), den Hong-chila (Qonggirat) und den Yich’ilihssü (Ikires) haben die Fünf vor der Gründung des Reiches bei dem grossen Werk (der Einigung) mitgeholfen. Danach, als T’aitu (Činggis) den Thron bestiegen hatte, erliess er den Befehl, dass ihre Söhne und Enkel, jeder dem Eigennamen zufolge, der als Sippennamen diente, die Bezeichnung ‘fünf t’ouhsia’ tragen sollte”⁴⁸ (Жүрчидэй Уруудай овгийн хүн. Түүний өвөг Начин баатар нь цэрэг дайны хэрэг, баатар зоригоороо нэр гарчээ. Түүний удмын нэгэн хэсгийг Уруудай, нэгэн хэсгийг нь Мангуд хэмээмү. Жалайр, Хонгирад, Ихирэсийн хамт тавуул улс байгуулах их үйлст хүчин зүтгэжээ. Тайзү их суурин залгамжлаад тэдний үр ач нарыг овгийн

⁴⁵ Д.Гонгор. *Халх товчоон*. II. Халх монголчуудын нийгэм-эдийн засгийн байгуулал (XI-XVII зуун). УБ., 1978. т. 265

⁴⁶ Ш.Нацагдорж. *Монголын феодализмын үндсэн замнал (түүхэн найруулал)*. УБ., 1978. т. 58

⁴⁷ Ratchnevsky Paul. Zum Ausdruck “T’ouhsia” in der Mongolenzeit. *Collectanea Mongolica. Festschrift Rintchen. Asiatische Forschungen*. Vol. 17. Wiesbaden. 1966. pp. 173-191

⁴⁸ Ratchnevsky Paul. Zum Ausdruck “T’ouhsia” in der Mongolenzeit. *Collectanea Mongolica. Festschrift Rintchen. Asiatische Forschungen*. Vol. 17. Wiesbaden. 1966. pp. 173-174 (Б.Нацагдоржийн орчуулгаар авав.)

нэр болгон хэрэглэдэг өөрийн нэрийнхээ өмнө таван t'ouhsia хэмээн нэрлүүлж байхыг зарлиг болов) хэмээн орчуулжээ. Эндээс харвал таван t'ouhsia гэдэг нь шагнал бөгөөд анх 1206 онд Чингис хаан суугаад улс байгуулах хэрэгт зүтгэсэн гавьяаг нь үнэлэн таван аймгийг шагнажээ гэж тайлбарлажээ. П.Рачневский авгайн эшилсэн бичвэрүүдээс харахад “арван t'ouhsia” болон “таван t'ouhsia” гэдэг нь эхлээд цэргийн албанд зүтгэж умард Хятадад хувь өмч газар олсон Мухалийн цэргийн монгол жанжидыг хэлж байсан бол дараа нь тэдний цэргийн анги болон захирагчдыг хэлдэг болсон болох нь тодорхой байна. Харин “арван t'ouhsia”-гийн нөгөө таван анги нь ямар ангиуд байсан нь тодорхойгүй ажээ.⁴⁹

Ш.Нацагдорж авгай “Юан улсын судраас үзэхэд бүр Чингисийн хаан сууж байх үед түүний шадар хүмүүст “түшээ” хэмээх харьяалах нутаг шагнаж байжээ. Энэ бол түшиг тулгуур гэсэн монгол үг болох нь дамжиггүй. Зарим эрдэмтдийн, тухайлбал П.Рачневский, Ш.Ивамүра нарын түшээ гэдгийг феодалын эзэмшил нутаг хэмээн үзсэн саналыг бид зөвшөөрөх бөгөөд уул томьёог “тушаал” гэсэн үгнээс гаралтай гэж тайлбарласныг харин зөвшөөрөхгүй”⁵⁰ гэж бичсэн юм. Үнэн хэрэг дээрээ П.Рачневский авгай өгүүлэлдээ түшээ гэдэг феодалын эзэмшил нутаг байсан гэж хэлээгүй, харин умард Хятадад дээрх таван тоу шиа (t'ouhsia), арван тоу шиа (t'ouhsia) гэдэг цэргийн дарангуй суусан газар орныг бас түшээгийн газар гэж хэлдэг, ойлгодог байсан гэж бичсэн байна. Өөрөөр хэлбэл, энэ нь Монгол нутагтай ямар ч хамаагүй гэсэн үг юм. Таван түшээ гэдэг нь дээрх таван аймгийн дарангуй цэргийн зохион байгуулалтын бүтцийг хэлж байгаа бөгөөд “тоу шиа” (t'ouhsia) гэдэг үгийг Хятан улсын үед хятад хэлэнд нэвтэрсэн үг, монгол хэлний түшээ гэдэгтэй холбоогүй, эртний хятад хэлийг сэргээсэн байдлаас үзэхэд өөр дуудлагатай байна, харин монголын туг буюу дохио гэдэг үгтэй гарал нэг байж магадгүй гэж үзжээ.⁵¹

Миний бодоход Ш.Нацагдорж авгай “Юань улсын судар”-ын мэдээг буруугаар ойлгож, өөрөөр тайлбарласан байна. Тэрбээр “Энэ таван аймгуудын тэргүүн ахлагчид Тэмүжинд үнэнч, шударга үйлчлэн зүтгэж, Монголын тулгар төрийг байгуулах, Монгол туургатныг нэгтгэхийн төлөөх тэмцэлд их тус хүргэсэн учраас таван аймгийн толгойлогч нарт “түшээ” цол өргөмжлөн, өргөн их эрх дархтай болгожээ”⁵² гэж бичсэн юм. Гэтэл дээрх орчуулгад Чингис хаан тэдгээр аймгийн удирдагч нарт түшээ гэсэн тусгай цол, их эрх дарх өгсөн тухай бичээгүй, харин таван харьяат эсвэл таван түшээ гэж нэрийдэх тухай дурджээ. Ш.Нацагдорж авгай “Юань улсын судар”-ын мэдээг сайн нягтлалгүйгээр, мөн П.Рачневский авгайн бичснийг буруу ойлгоод өөрөөр тайлбарлаад явчихсан ажээ.

“Юань улсын судар”-т гарч буй харьяат эсэхүл түшээ хэмээн нэрлэгдэх болсон таван аймаг Их Монгол улс байгуулагдахаас аль өмнө өөрийн гэсэн нутаг дэвсгэртэй байсан нь бүхэнд илэрхий. 1206 онд Чингис хаан мянганы зохион байгуулалтыг сэргээн засаг захиргааны үндсэн нэгж болгон хэрэглэхэд ч дээрх таван аймгийн уг язгуур нутаг нэг их өөрчлөгдөөгүй байх гэж үзэж байна. Учир нь

⁴⁹ Ratchnevsky Paul. Zum Ausdruck “T'ouhsia” in der Mongolenzeit. Collectanea Mongolica. Festshrift Rintchen. Asiatische Forschungen. Vol. 17. Wiesbaden. 1966. p. 178 (Б.Нацагдоржийн орчуулгаар авав.)

⁵⁰ Ш.Нацагдорж. *Монголын феодализмын үндсэн замнал (түүхэн найруулал)*. УБ., 1978. т. 56

⁵¹ Ratchnevsky Paul. Zum Ausdruck “T'ouhsia” in der Mongolenzeit. Collectanea Mongolica. Festshrift Rintchen. Asiatische Forschungen. Vol. 17. Wiesbaden. 1966. pp. 181-182 (Б.Нацагдоржийн орчуулгаар авав.)

⁵² Ш.Нацагдорж. *Монголын феодализмын үндсэн замнал (түүхэн найруулал)*. УБ., 1978. т. 56

тэдгээр аймгууд Тэмүжинд үнэнчээр зүтгэж гавьяа байгуулсан тул тэдний бэлчээр нутаг, хүн амын бүрэлдэхүүнийг нэг их хөндөх ёсгүй билээ. Тиймээс тэдэнд “түшээ” хэмээн нэрийдэх тусгай газар нутаг өгсөн гэдэг нь үнэмшил муутай юм.

Их Юань улсын үед Чингис хааны үйл хэргийг магтан алдаршуулах олон ажил хийж байсан билээ. Их хаанд үнэн хүчээ өгч зүтгэсэн таван аймгийн ноёдын үр удмынхныг бусдаас онцгойлон үзэж байсныг “Юань улсын судар”-т тэмдэглэн үлдээснийг хожмын судлаачид тэдгээр аймгийг түшээ цолтой, улмаар түшээ газар нутагтай хэмээн хэтрүүлэн гуйвуулж нэрийдэх болсноор ийм буруу ойлголт бий болжээ.

Хэрэв үнэхээр Чингис хаан өөрөө энэ таван аймагт түшээ цол өгсөн бол тэр талаар “Монголын нууц товчоон”, “Судрын чуулган” зэрэгт эрхбиш товч хэдий ч дурдах ёстой байлтай санагдана. “Монголын нууц товчоон”-д түшээ гэсэн үг гардаггүй агаад харин түшив, түшээд, түшиж, түшин, түшрүүн, түшсү, түшье зэрэг үг байдаг.⁵³ Сурвалж судлалын салбар ухааны үүднээс “Юань улсын судар”-ын дээрх мэдээ өөр бусад сурвалжийн мэдээгээр сайтар нотлогдохгүй байгаа тул итгэмж багатайд тооцогдоно. Мөн нөгөөтэйгүүр “Юань улсын судар”-т буй ноёд язгууртны тухай мэдээг тайлбарлахдаа тэдний “түшээ газар”-тай байсан гэж шууд бичих нь буруу юм.

Үнэхээр түшээ нутаг байсан бол тэр нь газар эзэмшил үү? эсвэл газар өмчлөл байв уу? П.Рачневский авгай түүнийг феодалын эзэмшил газар гэж үзсэн гэж Ш.Нацагдорж авгай андуурсан билээ. Уг нь П.Рачневский авгай түшээ газар байсан гэж ер бичээгүй агаад умард Хятадад таван тоу шиа (t'ouhsia)-гийн таван анги дарангуй цэрэг суухдаа тус тус хувь өмч иргэн олж авсан, тэднээс жилийн тогтмол алба авдаг байсан тухай дурдсан байна.⁵⁴

Мөн Ш.Нацагдорж авгай “Монголын жинхэнэ бодит байдалд ‘түшээний’ толгойлогч нь өөрийнхөө аймгийн газар нутаг, хүн амыг захиран өмчлөгч бөгөөд Ш.Ивамүра тэдгээрийг мянганы системд багтдаггүй гэсэн нь зөв бололтой”⁵⁵ гэж бичсэн байдаг. Харин Ш.Ивамүра авгай “түшээ” гэдэг газар байсан, тэр нь мянганы тогтолцоонд багтдаггүй байсан гэж бичсэн гэдэг нь эргэлзээтэй. Ш.Ивамүра авгайн үзснээр, түшээ гэх үг Хятан улсын үед анх тэмдэглэгдсэн нь хааны гэр бүлийн язгууртнуудын хувийн цэрэг бүхий засаг захиргааны бие даасан эрхтэй онцгой нэгжийг хэлдэг байжээ. Харин түшээ гэх үгийн гарал тодорхойгүй байв. Их Юань улсын Хубилай хааны үед Хятан улсын үеэс “толгойлогчийн дор” хэмээх ханзны утгаар хэрэглэгдэж байсан түшээ touxia 頭下 нь засаг захиргааны нэгжийн утгаар “дор оруулах”, “дор захируулах” хэмээх утгатай touxia 投下 гэдэг ханзаар солигдсон ажээ. Юань улсын үед аймаг гэдэг нь Юань улсаас өмнө, хойно хэрэглэж байсан утгаар Хэрэйд аймаг, Еншөөбү аймаг гэдэг шиг биш, харин Алтан ургийн олон вангуудад соёрхлоор хүртээж байсан автономит бүсийг аймаг аймаг айма 愛馬 түшээ гэж адилхан нэрлэж байсан гэж үзжээ.⁵⁶ Үүнээс үзэхэд, Их Юань

⁵³ *Word- and Suffix- Index to The Secret History of the Mongols based on the Romanized Transcription of L.Ligeti.* Compiled by H.Kuribayashi and Choijinjab. Sendai. 2001. pp. 850

⁵⁴ Ratchnevsky Paul. Zum Ausdruck “T’ouhsia” in der Mongolenzeit. *Collectanea Mongolica. Festshrift Rintchen.* Asiatische Forschungen. Vol. 17. Wiesbaden. 1966. p. 175 (Б.Нацагдоржийн орчуулгаар авав.)

⁵⁵ Ш.Нацагдорж. *Монголын феодализмын үндсэн замнал (түүхэн найруулал).* УБ., 1978. т. 56

⁵⁶ 岩村忍 1968 『モンゴル社会経済史の研究』京都大学人文科学研究所 (Шинобу Ивамүра. *Монголчуудын нийгэм ба эдийн засгийн түүхийн судалгаа.* Киото. 1968) т. 410-411 (Г.Мандалсүрэнгийн орчуулгаар авав.)

улсын үеийн тоу шиа аймаг гэдэг нь Их Монгол улсын мянган бус, харин олон ван нарт Хятадын нутгаас олгосон эзэмшил нутгийг хэлдэг байв гэж тайлбарласан байдаг.

П.Рачневский авгай тоу шиа гэсэн хэллэг Юань улсын сүүл үед хэрэглэгдэхээ больсон гэж үздэг. Тэрбээр үүний учрыг “Das Schwinden des Ausdrucks t’ouhsia aus den Texten Ende der Yüan steht wahrscheinlich in Zusammenhang mit dem Wandel des Aranagensystems und der Militärischen Organisation”⁵⁷ (Юань гүрний сүүл үеийн баримт бичгүүдээс t’ouhsia гэсэн хэллэг алга болсон нь ван, ноёд язгуутнуудын эзэмшил болон цэргийн зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой байж мэдэх юм) хэмээн үзсэн ажээ. Монгол хэлний түшээ, хятадын тоу шиа гэх хоёр өөр үгийг зарим судлаач андууран ойлгосон нь түшээ газар нутаг гэдэг зүйл Монголд байсан гэх үзлийн уг үндэс болсон байна.

Мянганы тогтолцоо ба түшээ. Дараагийн асуулт нь мянганы тогтолцооноос гадуур “түшээ” гэсэн нэртэй таван аймаг бие даан оршиж байсан уу? гэдэг юм. Уг нь Уругуд, Мангууд, Ихэрэс, Жалайр, Хонгирад аймгууд 1206 оноос “гаднадус мянгад—qadanadus minqad” буюу гадаад мянганы зохион байгуулалтад орсон байв.

1206 онд Чингис хаан улс байгуулахад хүчин зүтгэсэн хүмүүсийг мянганы ноён өргөмжлөхөд дээр нэр гарах аймгууд болон түүний тэргүүлэгчид мянганы ноён, хүн ам нь мянганы хүмүүс, нутаг дэвсгэр нь мянганы газар болсон билээ. Харин зарим аймгийг арай өөрөөр авч үзэж, бүхлээр нь мянгалсан тохиолдол байдаг.⁵⁸ Үүнд энд яригдан буй таван аймгаас Уругуд, Хонгирад, Ихэрэс гурав багтана. Уругуд, Ихэрэс аймгууд дайн тулаанд тэргүүлэн оролцож онцгой гавьяа байгуулсан бол Хонгирад аймаг Чингис хааныг ялагдан ядарч явахад нь эсэргүүцэлгүй дагаар орж хүч чадлаа сэлбэхэд ихэд тусалжээ. Учир тиймийн тул Чингис хаан дөрвөн мянган Уругуд, гурван мянган Хонгирад, хоёр мянган Ихирэсийг бусадтай нийлүүлгүй тусад нь мянган болгосон билээ.

“Юань улсын судар”-г Жүрчидэйд “... dörben mingyan kümün-i jakirayulun”⁵⁹ (... дөрвөн мянган хүнийг захируулан) хэмээн бичсэн нь “Монголын нууц товчоон”-ы “ibaqa- yüan cimada ökbe dörben minqat uru’ud-üyan ci medejü bayiqu ülü-’ü aqū ci ke’en soyurqaju jarliq bolba”⁶⁰ (Ибаха юугаан чамд өгөв. Дөрвөн мянган Уругудаа чи мэдэж үлүүгү аху чи хэмээн соёрхож зарлиг болов) гэсэн мэдээтэй яв цав таарна.

Дээрх хэрэг явдлын учрыг сайн нягтлахгүйгээр энэ таван аймгийг тусгайлан салган авч тэднийг “түшээ” гэдэг тусгай газартай байсан, тэр нь газар эзэмшлийн нэг хэлбэр байсан, тэр нь мянганы газраас тусдаа нутаг дэвсгэр юм гэх зэргээр буруу хөөж тайлбарласан хэрэг болов уу хэмээн үзэж байна.

Их Юань улсын үед мянганы зохион байгуулалт суларсан хэдий ч нутаг дэвсгэрийн шинэ хуваарилалт хараахан хийгдээгүй, Их Монгол улсын үеийнх шигээ байсан хэмээн үзэж байна. Харин Их Юань улсын төгсгөл үеэс мянганы тогтолцоо

⁵⁷ Ratchnevsky Paul. Zum Ausdruck “T’ouhsia” in der Mongolenzeit. Collectanea Mongolica. Festshrift Rintchen. Asiatische Forschungen. Vol. 17. Wiesbaden. 1966. p. 181

⁵⁸ Ж.Гэрэлбадрах. Монголын дунд үеийн мянганы зохион байгуулалт. *Акта Хисторика*. т. XVI. УБ., 2015. т. 59-93

⁵⁹ *Юань улсын судар*. дэвтэр 120. Зөчидэй. Хятад хэлнээс орчуулсан Дэмчигдорж. Монгол улс. Үндэсний номын сан. т. 219

⁶⁰ Index to The Secret History of the Mongols by the Igor de Rachewiltz. *Uralic and Altaic series*. Volume 121. Indiana University Publications. Bloomington. 1972. p. 120

аажмаар суларч урьдын адилаар аймгаараа, хүрээгээр амьдрах ёсонд шилжих үйл явц зарим талаар эхэлсэн бололтой харагдана. Монголчуудын олонхи эх нутагтаа буцаж ирэхэд сонгодог мянганы тогтолцоо үндсэндээ эвдрээд байв.

Их Юань улсын үед Монголын түшээ гэдэг цол байгаагүй ч хятадаар “жү гуо” 柱国, “шан жү гуо” 上柱国 буюу монгол хэлээр улсын түшээ гэж орчуулан хэвшсэн ноёдын цол байсныг “Юань улсын судар”-т тэмдэглэн үлдээжээ. Түшиг тулгуур гэсэн утгатай жинхэнэ “түшээ”, “түшээт” гэдэг цол арай хожуу “Дөчин, Дөрвөн хоёрын” Монгол улсын (XIV-XVII зууны) үеэс хэрэглэгдэх болсон билээ.⁶¹

Дүгнэлт. Чингис хааны нэгдсэн улс байгуулах хүнд хэцүү тэмцэлд байлдаанч Уругуд, Мангуд аймаг чухал үүрэг гүйцэтгэж байсан, хаан тэдний гавьяаг ихэд үнэлж байв. Өөр бусад аймгууд ч бас багагүй тус хүргэсэн тул хожмын судлаачид “Юань улсын судар”-т гарах тоу шиа гэх үгийг монгол хэлний “түшээ” гэдэг цолтой андууран арай өөр утгаар гуйвуулан тайлбарласан ажээ.

Бидний түүхчид “Юань улсын судар”-т гарах тоу шиа (投下 t'ouhsia) гэх үгийг монголын “түшээ” гэдэг үг хэмээн андуу ойлгож тайлбарлах явцдаа “түшээ” цол, “түшээ цолтны эрх мэдэл”, “түшээ газар” гэсэн ойлголтуудыг зохион гаргаж иржээ. Ингэхдээ түүхийн судалгаанд өргөн хэрэглэх болоод удаж байгаа “үстэй бол бөөстэй байна” гэж зохиомол ойлголт бий болгодог “бөөсний арга” хэрэглэжээ. Уг аргаар түшээ гэдэг үг байгаа бол түшээ цол байна. Түшээ цол байгаа бол түүнийг дагасан тусгай эрх мэдэл байна. Түшээ цолтой эзэн байгаа бол түшээ аймаг байна. Түшээ аймаг байгаа бол түшээ газар нутаг байж таарна гэсэн гаргалгаа хийжээ. Чингэж “түшээ” гэдэг нэртэй газрыг зохиомлоор бий болгож, улмаар түүнийг газар эзэмшлийн нэгэн хэлбэр хэмээн бичиж тайлбарлах болсон ажээ.

Төгсгөл. Дээрх өгүүлсэн бүхнээс үзэхэд, Их Монгол улс, Их Юань улсын цагт “соёрхол нутаг”, “түшээ нутаг” гэсэн газар өмчлөлийн хэлбэр байсан гэдэг нь түүхэн баримт сэлтээр нотлогдохгүй байгаа тул энэ талаарх бүх судалгаа, таамагнал ор хоосон зүйл төдий болж хувирна.

Бас Юань улсын судар”-т гарах “Тайцу-гийн гавьяат сайд Боругули, Борчу, Мухули, Чулуун” дөрвийг түшээ байсан гэж үзсэн байна. (Ийм үг байхгүй байна) Гэтэл Дандаагийн орчуулгад тэднийг “дөрвөн сэцэн”⁶² хэмээн бичсэн ажээ.

⁶¹ Ж.Гэрэлбадрах. “Дөчин, Дөрвөн хоёрын” Монгол улсын язгууртны цол зэрэг. УБ., 2010. т. 99-100

⁶² Юань улсын судар. дэвтэр 99. Цэргийн тэмдэглэл. Хятад хэлнээс орчуулсан Дэмчигдорж. Монгол улс. Үндэсний номын сан. т. 5

ABSTRACT

J.Gerelbadrakh

Were there territories of “soyurqal” and “tüsiy-e” which existed in the Great Mongol State ?

By the historical study, during the Great Mongol State (Yeke Mongy ol Ulus) there were in three forms of territory properties existed: khan’s territory, private property territory for khan’s family, privilege darqan’s territory and was a form of land ownership: mingy an’s (thousand) pasture.

In this paper, I attempt to examine whether there “soyurqal nutuγ” (soyorqol territory) and “tüsiy-e nutuγ” (tushee territory) existed or not. The question is that there were another separate forms of pastures use in the Great Mongol State.

After historical sources were investigated, such as “The Secret History of the Mongols”, The Compendium of the Chronicles” and “Yuan shi”, it cleared that there was not existed a form of “soyurqal nutuγ” (soyorqol territory) in the land ownership at that time. The “ᠰᠣᠶᠢᠷᠻᠠᠯ –soyurqal” is regard expression of the a word which means to give, present as a gift, to award. Some scholars confuse on this word, it was artificially derived a new form of the land ownership “soyurqal nutuγ” in the era of the Chinggis khan.

Also they composed a form, which was called “tüsiy-e nutuγ” (tushee territory) without any enough historical sources acknowledgment. They identified wrong chinese character “投下 tou xia” which occurs in the “Yuan shi” as mentioned of Chinggis khan’s brave Urugud and Mangut tribes, “tüsiy-e” (tushee) is a word in Mongolian. The word “ᠲᠦᠰᠢᠶᠡ –tüsiy-e” means a support or a relief. There was no any a form of “tüsiy-e nutuγ” (tushee territory) pasture ownership in existing during the Great Mongol State.